



ГЕОМЭП ХХК

Геодези, газрын зургийн үйлдвэрлэл, үйлчилгээ
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Их Төгрөг 15,
Рангатайн ХХК-ийн байр 201 тоот,
Утас: 31 45 97 99164934 Факс: (7611) 314597
E-mail: Сэнжирял.С.Т.Өвөрсайхан

ХОНГОР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

2024 оны 03 сарын 11-ны өдөр

№16/24

Улаанбаатар хот

Тодруулга авах тухай

Манай компани нь Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлан Геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулдаг.

"Хонгор сумын Засаг даргын тамгын газар"-аас зарласан "Газар зүйн нэрийн тодруулалт" ДУАХОСЗДТГ/202402030 дугаартай тендер шалгаруулалтад манай компани оролцохоор материалаа бэлтгэж байна.

"Газар зүйн нэрийн тодруулалт" хийх ажлын хүрээнд тухайн сумын нутаг дэвсгэрт байгаа газар зүйн нэрийн суурин судалгаа, хээрийн судалгаа, газар зүйн нэр бүрийг солбицолжуулах, нэр бүрд хувийн хэрэг бүрдүүлэх, газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, газар зүйн нэрийн зураг зохиох зэрэг ажлуудаас бүрдсэн төсөл байдаг. Эдгээр үе шатны ажлуудыг хийхэд газар зохион байгуулагч тус бүр 2 байх шаардлага байхгүй бөгөөд энэ ажлыг зөвхөн газрын зурагтай ажиллах чадвар бүхий геодезийн инженерүүд хийдэг ажил бөгөөд нэрийн зураг зохиох ажлыг нь зураг зүйч инженер хяналт тавих бодлогыг "Геодези, зураг зүйн тухай" хуулийн хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар баримталж байгаа билээ. Газар зүйн нэрийн судалгаа тодруулалт хийх ажил нь ийм учраас "Геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөл"тэй байгууллага хийх ёстой байдаг болно.

Иймээс Танай тендерийн Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан үйлчилгээ үзүүлэх хүний нөөц заасан шаардлагаа эргэн харахыг хүсье.

Энэ асуудлаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас тодруулга, лавлагаа авч болно.

ЗАХИРАЛ



Ю.ЧҮЛТЭМ



ДАРХАН УУЛ АЙМАГ
ХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГА

45025 Дархан-Уул аймаг, Хонгор сум

2024.03.13 № 1/133
танай _____-ны № _____-г

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн 2024 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 16/24 тоот албан бичигтэй танилцлаа.

Тус сумын Засаг Даргын Тамгын газраас “Газар зүйн нэрийн зургийн тодруулалт” ДУАХОСЗДТГ/202402030 дугаар бүхий тендер шалгаруулалтыг 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж байна.

Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 246 дугаар тушаалаар батлагдсан “Геодези, Зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын дагуу тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагад өөрчлөлт оруулсан болно.

ЗАСАГ ДАРГА



Т.АТАРХИШИГ